

ХӨВСГӨЛ АЙМАГ ЦАГААННУУР СҮМҮН ЕБС

ЦАГААННУУР СҮМҮН СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ Ч. ОЮУНБАДАМ



ХӨВСГӨЛ АЙМАГ ЦАГААННУУР СҮМҮН ЕБС-ИЙН
“ТҮЛШ ХАЛААЛТ ХУДАЛДАН АВАХ” ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ

Төслийн дугаар: ХӨАЦНСЗДТГ/20240202038

2024ОН

ҮННИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2024-04-15

Хөөсгөл аймаг Цагааннуур сумын Ерөнхий Боловсролын Сургууль нь сонгогдсон эрх бүхий тендерт оролцогчдоос Ерөнхий боловсролын сургуулийн Түвш, халаалт нийлүүлэх тухай үнийн санал ирүүлэхийг урьж байна.

Үнийн санал ирүүлэх барааны техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **[2024 оны 04 сарын 22 өдөр 12 цаг 00 минут]**-аас өмнө

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2024**-ны 04 сарын 22 өдрийн **12 цаг 30 минут** нээнэ.

Дотоодын давуу эрх тооцно.

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

Үнэлгээний хорооны дарга: Г. Түмэн-Өлзий 80221236

Нарийн бичгийн дарга: Ю.Болортамир 80641100
/bolortamiryumchinsuren@gmail.com/

Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий оролцогч ба бүхий бараа**
- 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн тендерт өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер **эрх шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан** байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
- 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
- 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 2.3. Тендерт оролцогч тендерийн материалд Хувь хүний нууцын тухай болон Байгууллагын нууцын тухай хуулиудаар ил болгохыг хориглосон мэдээллийг тусад нь хавтаслаж ирүүлнэ. Тус хавтасны эхэнд тэдгээр мэдээллийг нууцлах үндэслэлийг бичгээр тайлбарлаж, тендерт оролцогчийн итгэмжлэгдсэн этгээд гарын үсгээр баталгаажуулна. Эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох ТШӨХ-д заасан баримт бичиг, тендерийн баримт бичигт заасан маягтуудыг нууцлахгүй ирүүлнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
- 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
- (а) Унийн санал;
 - (б) Унийн болон нийлүүлэлтийн хуваарь.
 - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг.
 - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл.
 - (д) [Бэлтгэж ирүүлэх шаардлагатай бусад материалыг жагсаана.]
- 4. Тогтмол үнэ**
- 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Унийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн ба нөхцөлүүд**
- 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын **тодорхойлол шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах түүрэгтэй**. Нийлүүлэх бараа нь техникийн **арилжааны тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана**.
- 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш 30 хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарьт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь запруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХУСНЭГТ

ТОӨЗ-НЫХОЛБОГДОХ ЗААЛТ	Шалгуур үзүүлэлт
ТОӨЗ 1.1	<p>Сүүлийн 2 жилийн санхүүгийн тайлан аудитын дүгнэлтийн хамт e-balance программд санхүүгийн тайлан шивэгдсэн байх.</p> <p>Сүүлийн 2 жилийн туршлагын мэдээлэл /түлш, халаалт нийлүүлэх ажиллагаатай ижил төстэй бараа, үйлчилгээг нийлүүлж байсан туршлагатай байх/.</p> <ol style="list-style-type: none"> 1. Сүүлийн 2 жилд / 2022, 2023 он/ түлш, халаалттай ижил төстэй бараа, үйлчилгээ нийлүүлснийг нотлох гэрээ /өмнөх захиалагчтай байгуулсан гэрээ/-ний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, нотлох баримтууд /нотариатаар баталгаажуулж/ ирүүлэх 2. Сүүлийн 2 жилийн ба 2022, 2023 онуудын туршлагын мэдээлэл /гэрээгээр гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/; 3. Голлох мэргэжилтэн, ажилтны танилцуулга, мэргэжлийн үнэмлэх, дипломны хуулбар 4. Сүүлийн 2 жилийн борлуулалтын орлогын дундаж хэмжээ төсөвт өртгийн 80%- аас багагүй байх. 5. Ижил төстэй ажлын сүүлийн 2 жилийн дундаж өртөг төсөвт өртгийн 70%-аас багагүй байх 6. Сүүлийн 2 жилийн ижил төстэй ажлын нотлох баримтууд ирүүлэх.\гэрээний хуулбар, нотлох баримтууд\ 7. Тендерт оролцогч үнийн өсөлтөөс урьдчилан сэргийлэх тухай, үнийн өсөлтөөс хамаарах эрсдлийг өөрөө хариуцах тухай албан бичгээр мэдэгдэл ирүүлэх. 8. Тендерт оролцогч уг тендерт шалгарсан тохиолдолд санал болгосон үнэд багтаан бүтээгдэхүүнийг нийлүүлж гэрээний үүргээ биелүүлэх баталгааг бичгээр гаргаж ирүүлнэ. 9. Тендерийн баримт бичгийн 6, 7-р бүлэгт заагдсан гэрээний ерөнхий болон тусгай нөхцөл, маягт зэргийг зөвшөөрсөн тухай албан бичгээр мэдэгдэл гаргаж ирүүлнэ, 10.Харилцагч банкнаас хугацаа хэтэрсэн өр төлбөргүй тухай лавлагаа, тодорхойлолтыг тендерт оролцогч этгээд болон компаний хууль ёсны удирдлага, /ТҮЗ-ийн гишүүд/ тус бүрээр авч ирүүлэх, 11.Татварын хугацаа хэтэрсэн өр төлбөргүй болох, татварын байгууллагад татварын тайлангаа өгдөгийг нотлох тодорхойлолтыг ирүүлэх, 12.Нийгмийн даатгалын өр төлбөргүй болон гэрээ хэрэгжүүлэх санал болгосон ажилтнуудын нийгмийн даатгалын шимтгэлийг төлсөн зэргийг нотлох тодорхойлолт ирүүлэх, Нийгмийн даатгалын тайланг НД-7, НД-8дугаар маягтын дагуу сүүлийн 6 сарын тайланг баталгаажуулсан ирүүлэх, 13. Шүүх, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудаас ял шийтгэлгүй, гэмт хэрэгт холбогдоогүй тухай тодорхойлолт ирүүлэх 14. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан нөхцөл байхгүйг бичгээр ирүүлэх. /Тендерт оролцогч нь үнэлгээний хорооны

	<p>гишүүдэд нөлөөлөх, нөлөөлөхийг оролдсон нь баримтаар нотлогдвол тендерээс татгалзана./</p> <p>15. Улсын бүртгэлийн гэрчилгээний хуулбар /нотариатаар баталгаажуулж ирүүлнэ/</p> <p>16. Захиалагчийн техникийн тодорхойлолтод заасан шаардлагыг хангаж ажиллах баталгааг гаргаж ирүүлэх</p> <p>17. Ойн менежментийн төлөвлөгөөтэй байх</p> <p>18. Тендерт оролцогчийн инженер техникийн ажилтаны иргэний үнэмлэхний хуулбар, мэргэжлийн үнэмлэхний хуулбар ирүүлэх</p> <p>19. Ажлын байрны дүгнэлт ирүүлэх</p> <p>20. Улсын мэргэжлийн хяналтын газрын дүгнэлттэй байх /хуулбарыг наториатын баталгаатай ирүүлэх/</p> <p>21. Мэргэжлийн хяналтын газар, аймгийн аудитын газраас сүүлийн 2 жилд /2022, 2023 он/ тавьсан акт, дүгнэлт, зөвлөмжийг хэрэгжүүлсэн тухай нотлох баримтыг ирүүлэх /мэргэжлийн хяналт, аудитын газраас акт, дүгнэлт, албан шаардлага авсан тендерт оролцогчид хамаарна/</p> <p>22. Тендерт оролцогчийн захирал болон ажилтнуудын иргэний үнэмлэхний хуулбар, дипломын хуулбар, мэргэжлийн үнэмлэхний хуулбар, нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар</p> <p>23.</p> <p>Тендерт оролцогч тухайн ажилд шаардлагатай дараах зөвшөөрөлтэй байх шаардлагатай. Үүнд: Ойн мэргэжлийн байгууллага, нөхөрлөл байх.</p> <p>Дараах үндсэн тоног төхөөрөмжийг ажлыг гүйцэтгэх хугацаанд (өөрийн, түрээслэх, хөлслөн авах г.м.) бэлэн байлгах шаардлагатай. Үүнд: [тоног төхөөрөмжийг жагсаана]</p> <p>24. Ажлын үе шатны хуваарийг боловсруулан тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтанаар баталгаажуулж ирүүлэх</p> <p>25. Санхүүжилтийн хуваарийг боловсруулан тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтанаар баталгаажуулж ирүүлэх</p> <p>26. Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн төсөвт өртөгийн 30 хувиас багагүй байх</p> <p>27. Тендерт оролцогч гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай тоног төхөөрөмж машин механизмийн судалгааг ирүүлнэ.</p>										
	<table border="1"> <thead> <tr> <th>№</th><th>Тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал</th><th>Тоо хэмжээ</th><th>Үйлдвэрлэ сэн улс, ашигласан жилийн тоо</th><th>Өөрийн хөрөнгө болон түрээсийн болохыг батлах /хуулбар ирүүлэх/</th></tr> </thead> <tbody> <tr> <td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table>	№	Тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал	Тоо хэмжээ	Үйлдвэрлэ сэн улс, ашигласан жилийн тоо	Өөрийн хөрөнгө болон түрээсийн болохыг батлах /хуулбар ирүүлэх/					
№	Тоног төхөөрөмжийн нэр, хүчин чадал	Тоо хэмжээ	Үйлдвэрлэ сэн улс, ашигласан жилийн тоо	Өөрийн хөрөнгө болон түрээсийн болохыг батлах /хуулбар ирүүлэх/							
ТОӨЗ 2.1	<p>Тендер хүлээн авах хаяг, эцсийн хугацаа нь:</p> <p>Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг Цагааннуур сум, 1 баатар, ЕБСургууль</p>										

	<p>Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Цаг: 12 цаг 00 минут</p>
ТОӨЗ 2.1	<p>Тендерийн нээлт хийх газар, хугацаа нь: Байгууллагын хаяг: Хөвсгөл аймаг Цагааннуур сум, I баг, ЕБСургууль. Давхар болон өрөөний дугаар: Хөвсгөл аймаг Цагааннуур сум, I баг, ЕБСургууль Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 22-ны өдөр Цаг: 12 цаг 30 минут</p>
ТОӨЗ 2.3	<p>Дөрөвдүгээр бүлгийн маягуудаас гадна эрх бүхий тендерт оролцогч болохыг нотлох дараах баримт бичиг, материалыг өөрийн тендертээ нууцлахгүй ирүүлнэ. Үүнд:</p> <ol style="list-style-type: none"> Дээрх нэмэлт материалындаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй баталгаажилтгүй ба зөрчил бүхий нотлох баримтууд ирүүлсэн тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно. Тодорхойлолтууд 30 хоногийн хугацаанд хүчинтэй байх ба хуулбар хувь ирүүлэх бол хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлж болно Оролцгчийн ирүүлсэн тендерийн материал нь баримт бичгийн стандартын шаардлага хангасан байна.
ТОӨЗ 6.2	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: Багцгүй

Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

- Барааны тодорхойлолт:** [Түлш, халаалт]
- Стандарт:** Захиалагч холбогдох стандартыг заана. Эсхүл [Тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно.] гэж бичнэ
- Баглаа, боодол:** [Барааг тээвэрлэх, хадгалах үеийн баглаа боодолд тавих нөхцөлийг тодорхой заана. Баглаа боодлын нөхцөлийг цаг уур, давс, барааны жин, ачих буулгах хэрэгсэл, далайгаар тээвэрлэх тохиолдолд хөлөг онгоцны тавцан дээр, эсхүл доор тээвэрлэх зэргийг харгалзаж тодорхойлно. Ачааг хэрхэн тэмдэглэх болон хаяглах, ямар баримт бичиг дагалдахыг энд тодорхойлно.]
- Бараа хүргэх газар:** [Хөвсгөл аймаг Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн хашаанд]
- Бараа нийлүүлэлтийн хуваарь:**

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Дугаар	Нийлүүлэх бүтээгдэхүүний нэр	Хэмжих нэгж	Нэг бүрийн үнэ	Нийт хэмжээ	Нийт үнэ
1					

Техникийн тодорхойлолт бэлтгэх санамж

Техникийн тодорхойлолтын зорилго нь захиалагчид шаардлагатай байгаа бараа болон холбогдох үйлчилгээний техникийн тодорхойлолтыг нарийвчлан тодорхойлоход оршдог.

Ойлгомжтой бөгөөд сайтар бэлтгэсэн техникийн тодорхойлолт нь захиалагчийн тавьсан шаардлагад нийцсэн, бодитой бөгөөд өрсөлдөх чадвартай тендер бэлтгэхэд тендерт оролцогчдод зайлшгүй чухал нөхцөл болно. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ өрсөлдөөнийг аль болох өрнүүлэх зарчмыг баримтлах ёстой бөгөөд үүний зэрэгцээ худалдан авах бараа, үйлчилгээний шинж чанар, материал, үйл ажиллагааны шаардлагдах стандартын талаар тодорхой тусгана. Эдгээрийг хангасан нөхцөлд л худалдан авах ажиллагааны хэмнэлттэй, үр ашигтай, шударга байх зорилго хэрэгжиж, тендерүүдийн шаардлагад нийцэх байдал баталгаажиж, тендерийг үнэлэх үнэлгээ зөв явагдана.

Гэрээнд өөрөөр заагаагүй бол бүх бараа, материал нь шинэ, ашиглагдаагүй, орчин үеийн загварын, мөн зураг төсөл, материалын хувьд сүүлийн үеийн хандлагыг хангасан байх нөхцөлийг техникийн тодорхойлолтод шаардвал зохино.

Өмнө хэрэгжсэн, ижил төстэй төслийн техникийн тодорхойлолтыг жишээ болгон ашиглах нь давуу талтай. Техникийн тодорхойлолтыг бэлтгэхдээ метрийн системийг ашиглана. Бүх салбарт хэрэглэж болох нийтлэг жишиг техникийн тодорхойлолт гэж байхгүй. Бүх төрлийн барааны стандарт буюу ерөнхий техникийн тодорхойлолт боловсруулж стандартчилах нь чухал ач холбогдолтой. Энэ стандарт техникийн тодорхойлолтыг тухайн бараанд нийцүүлэн, зохих өөрчлөлт оруулах замаар ашиглана.

Техникийн тодорхойлолтын шалгуур үзүүлэлтүүд нь хязгаарласан шинжтэй байж болохгүй. Бараа, материалын, техникийн тодорхойлолтодаль болох олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн стандартыг хэрэглэх шаардлагатай. Хэрэв Монгол Улсын үндэсний стандарт, эсхүл тухайлсан өөр стандартыг хэрэглэсэн тохиолдолд бараа, материал, шинж чанар нь энэ стандартад дүйцэх буюу түүнээс илүү бол хүлээн зөвшөөрнө гэж техникийн тодорхойлолтод заах хэрэгтэй.

Жишиг заалт: Стандарт болон кодын дүйцэх байдал

Гэрээнд өөрөөр заагаагүй бол техникийн тодорхойлолтод дурдсан нийлүүлэгдэх бараа, материал, тэдгээрийг турших стандарт, кодыг уг стандарт буюу кодын тухайн үед мөрдөгдөж буй хувилбарт тодорхойлсноор хэрэглэнэ. Үндэсний стандарт, кодыг заасан тохиолдолд түүнтэй дүйцэх, эсхүл түүнээс илүү чанартай олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн бусад стандарт, кодыг хүлээн зөвшөөрнө.

Барааны тэмдэг, каталогийн дугаарыг заасан шаардлагыг аль болох тавихгүй байна. Зайлшгүй шаардлагын улмаас эдгээрийг хэрэглэх бол түүний ард “Эсхүл түүнтэй дүйцэх” гэж нэмж заана.

Шаардлагатай тохиолдолд захиалагч зураг болон ажлын талбайн төлөвлөгөөг тендерийн баримт бичгийн хамт тендерт оролцогчдод өгнө. Үүнд мөн тендерт оролцогч зураг болон загварыг тендертэй хамт, эсхүл гэрээний хэрэгжилтийн явцад захиалагчид урьдчилан хянуулах зорилгоор ирүүлэхээр зааж болно.

Хэрвээ захиалагч техникийн тодорхойлолтын хураангуйг гаргуулахаар бол дараах хүснэгтийг ашиглан шаардлагатай мэдээллийг тусгаж өгнө. Тендерт оролцогч санал болгож буй бараа,

Үйлчилгээ нь уг шаардлагад нийцэж байгаа эсэхийг ижил хүснэгтээр харуулна.

Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга _____ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [тоо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойло лт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

- Бид тендерийг холбогдох журмын дагуу бусад тендерт оролцогчдод ил болгохыг үүгээр зөвшөөрч байна. Захиалагч бидний ирүүлсэн тендерийг нууцлах аливаа үүргээс бүрэн чөлөөлөгднө.

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/фа кс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

- 1. Шалгах болон турших**
- 1.1. Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.

2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
3. Оюуны өмчийн эрх	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
5. Баталгаат засварын хугацаа	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа [moor] жил байна.
6. Гэрээнд өөрчлөлт оруулах	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
7. Төлбөр	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш [ГТН-д заасан moor] хоногийн дотор шуурхай хийнэ.
8. Бараа нийлүүлэх хуваарь	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
9. Алданги оногдуулах	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
10. Үүргээ биелүүлээг үй-гээс гэрээг цуцлах	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.

- 11. Маргааныг шийдвэрлэх**
- 11.1. Талууд гэрээний үүргийн биелэлтэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- | | |
|---|--|
| 1. Шалгах болон турших (ГЕН – 1) | 1.1. [Гэрээний ерөнхий нөхцөлийн 1 дүгээр зүйлийг дэлгэрүүлэх шаардлагатай бол ямар шалгалт болон туршилтыг хэн, хэзээ хийх нөхцөлийг заана.] |
| 2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2) | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:

1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг заасан нэхэмжлэхийн хувь;
2) барааг хүргэсэн тухай баримт, төмөр замын болон тээврийн баримт;
3) үйлдвэрлэгчийн буюу нийлүүлэгчийн баталгаат засварын гэрчилгээ;
4) үйлдвэрийн буюу эрх бүхий байгууллагын шалгалтын гэрчилгээ;
5) барааны гарал үүслийн гэрчилгээ. |
| <p>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна.</p> | |
| 3. Баталгаат засвар (ГЕН-5) | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлага.

[Гэрээний ерөнхий нөхцөлийн 5 дугаар зүйл нь баталгаат засварын тухай нийтлэг заалтыг агуулна. Энэхүү нийтлэг заалтыг өөрчлөх шаардлага гарвал энд тусгана.] |
| 4. Төлбөр (ГЕН – 7) | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:

Гэрээний үнийн дүнгийн 100% хувийг барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.
Санхүүжилтийг техникийн тодорхойлолтод заасны дагуу гүйцэтгэлийг харгалзан хүлээж авах ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн олгоно. |
| 5. Алданги оногдуулах (ГЕН - 9)¹ | 9.1. Алданги оногдуулах хувь: 0.1%

Алдангийн нийт дүн: 10%-с хэтрэхгүй байх |

¹ Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ²

БАТЛАВ.

ЗАХИАЛАГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

НИЙЛҮҮЛЭГЧ

(Тамга, тэмдэг)

(Гарын үсэг)

(Албан тушаал)

[Тендер шалгаруулалт/гэрээний нэр] гэрээ.

Дугаар № [Тендер шалгаруулалт/гэрээний дугаар]

.....
хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож _____ оны __ сарын __ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг _____ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, _____ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь _____ нэр төрлийн барааг _____ оны __ дугаар сарын __ -наас _____ оны __ дугаар сарын __ -ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.

² Гэрээ байгуулах үед үүнийг хасна.

5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;
Бусад шаардлагатай баримт бичиг³;
Үнийн санал;
Гэрээний тусгай нөхцөл;
Гэрээний ерөнхий нөхцөл;
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;
Санхүүжилтийн хуваарь.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дүнг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:

[Албан тушаал, нэр]
[Гарын үсэг]

ТАМГА

[Захиалагчийн хаяг]
[Утас/факсын дугаар]
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

³ Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.